



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАЗАР**

402 дугаар байр, Рашаантын гудамж 4,
Рашаант 10 дугаар баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64107
Утас: (976) 70444017, 70442478
Цахим шуудан:hhaag.bkhl.gov.mn

2024.05.03 № 4/142

танай _____-ны № _____-г


Бүтээгдэхүүн устгуулах тухай

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газраас зохион байгуулж буй “Хүнсний аюулгүй байдал” арга хэмжээний хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5^{2.1} дэх заалт 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 08-00-02/13 удирдамжийн хүрээнд Баянговь сумын 5 дугаар багт байрлах “Их уул”, “Дэлгэрэх”, “Эгшиглэн”, “Оргил0”, “Мөнх мандах жаргалан”, “Мөнхөд дэлгэрэх”, “Аривжих эрдэнэ” зэрэг хүнсний худалдааны газруудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2024 оны 04 дүгээр сарын 17-ний өдөр Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч Ч.Жавзандулам, сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Ц.Мөнхтулга, Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн Б.Булганчимэг нартай хамтран хийв.

Шалгалтаар Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах болон хэрэглэх хугацаа хэтэрсэн хүнсний бүтээгдэхүүний худалдан борлуулсан нь “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 11.1.7 дэх (хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн;) заалтыг зөрчиж 64 нэр төрлийн 595 ширхэг 3397500 (Гурван сая гурван зуун ерэн долоо таван зуун мянган) төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг улсын байцаагч хураан авах акт үйлдэн устгах комисст шилжүүлж устгуулахаар шийдвэрлэв.

Хавсралтаар устгуулах хүнсний бүтээгдэхүүний нэрсийн жагсаалт болон улсын байцаагчийн 08-16-02/019/09, 10, 11, 12, 13, 14, 15 тоот актаар баталгаажуулалт болсон.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН ГҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.МӨНХТОГТОХ



642315149
D/2024/A4 албан тоот/



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/33

Өргөн

Г Орон тооны бус устгалын зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11 дэх заалт, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 8.10 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолын хавсралт "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ын 4.4, 4.5, 4.6, 4.7 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1, 5.3, 5.4, 5.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон тооны бус устгалын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Отгонжаргал-Тамгын газрын дарга
Гишүүд: Л.Сэргэлэнбаатар-Хэсгийн төлөөлөгч
Ц.Буянжаргал-Татварын улсын байцаагч
Ц.Мөнхтулга-Байгаль орчны улсын байцаагч
Нарийн бичгийн дарга: Б.Булганчимэг-Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл,
хоршоо хариуцсан мэргэжилтэн

2.Хяналт шалгалтаар илэрсэн хүнсний бүтээгдэхүүний сав, боодлын шошго алдагдсан, хүнсний хадгалтын горим зөрчсөн, хугацаа дууссан бараа бүтээгдэхүүнийг устгахыг ажлын хэсэгт даалгасугай.

3.Устгасан бараа бүтээгдэхүүний талаарх тэмдэглэл, акт үйлдэж танилцуулж байхыг ажлын хэсгийн ахлагч (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Н.Сугар-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



Б.БАТ-АМГАЛАН

642401064

БАЯНГОВЬ СУМ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Бүтээгдэхүүн устгасан тухай

2024 оны 06 сарын 04

Өргөн

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газраас зохион байгуулж буй “Хүнсний аюулгүй байдал” арга хэмжээний хүрээнд хүнсний худалдааны газруудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч Ч.Жавзандулам, Засаг даргын орлогч Н.Сугар-Эрдэнэ, Байгаль орчны хяналтын улсын байцаагч Ц.Мөнхтулга, байгаль хамгаалагч Б.Нямжаргал нарын хамт хийж шалгалтаар Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах болон хэрэглэх хугацаа хэтэрсэн, хаяг шошгололт алдагдсан 64 нэр төрлийн 595 ширхэг хүнсний бүтээгдэхүүнийг улсын байцаагч хураан авч акт үйлдэн устгах комисст шилжүүлэн ирүүлсэн.

Засаг даргын орлогч Н.Сугар-Эрдэнэ, Орон тооны бус устгалын зөвлөлийн дарга Д.Отгонжаргал, гишүүн хэсгийн төлөөлөгч Л.Сэргэлэнбаатар, гишүүн хүнс хариуцсан мэргэжилтэн Б.Булганчимэг, эрэн хайх, аврах бүлгийн ахлагч Т.Эрдэнэбилэг нарын хамт устгалыг хийж гүйцэтгэлээ.





ХЯНАСАН:
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА ~~Д.ОТГОНЖАРГАЛ~~

ТАЙЛАН БИЧСЭН:
ХҮНС ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН *Б.Булганчимэг* Б.БУЛГАНЧИМЭГ

